



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 8 сарын 14 өдөр

Дугаар 216


Улаанбаатар хот

Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бэст солюшн” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдсон Эрдэнэцогт овогтой Ариунааг бүртгэсүгэй.
2. Э.Ариунааг эрх бүхий албан тушаалтны бүртгэлд бүртгэсэнтэй холбоотой Эрдэнэболд овогтой Дөлгөөнийг бүртгэлээс хассугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН